



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/545

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоол тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, экспортын тогтвортой байдлыг хангах зорилгоор Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01/3404 дүгээр албан бичгийн хүрээнд “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс” болгох холбогдох үнэлгээ, судалгаа боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс” болгоход шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон нийгмийн үнэлгээг гаргах судалгааны ажлыг зохион байгуулж, дүнг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн дарга, аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3. Судалгааны ажлын шаардлагатай зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэх, ажлын тайланг Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдад уламжлахыг ажлын хэсгийн даргад даалгасугай.


4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
10 дугаар сарын 30 ны өдрийн 45 дугаар  
захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө  
оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт  
хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Аймгийн Онцгой байдлын газрын дарга

Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Аймгийн Боловсрол, Шинжлэх Ухааны газрын дарга

Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Бүх сумын Засаг дарга нар

\_\_\_ооо\_\_\_